



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.10.24 № 45

Хагас коксон шахмал түлшний
асуудлаар

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд гэрээт борлуулалтын 331 цэгээр 1535 тонн сайжруулсан шахмал түлш, 940 тонн хагас коксон шахмал түлшийг борлуулж байгаа гэх боловч бодит байдал дээр хүрэлцээгүй байгаагаас иргэд гал алдах нөхцөл бүрдсэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн айл, өрхийн хэрэгцээг хэрхэн тасралтгүй хангах, хагас коксон түлшний илч чанар, стандартыг хэрхэн баталгаажуулан хянаж байгаа талаар;

2.“Тавантолгой түлш” ХХК-д үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшийг хязгаартай олгохоор шийдвэрийн үндэслэл бүхий судалгаа, жингийн зөрүүтэй байдалд хяналт хийсэн талаарх мэдээлэл;

3.Тээвэр ложистик, борлуулалтын цэгүүд хүрэлцээгүй байдлыг бүрэн шийдвэрлэх асуудлаар авч байгаа арга хэмжээ;

4.Хагас коксон шахмал түлш агаарын бохирдлыг бодитойгоор бууруулах тооцоолол бүхий судалгаа байгаа эсэх;

5.Сайжруулсан болон хагас коксон шахмал түлш хэрэглэж эхэлснээс хойш одоог хүртэл угаарын хийд хордож эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөрөө хохирсон талаарх тоон мэдээлэл, одоогийн түлшний найрлага дээрх асуудлыг дахин үүсгэхгүй байх баталгаа бий эсэх лабораторийн болон хийсэн шинжилгээний талаарх мэдээлэл;

6.“Тавантолгой түлш” ХХК-ийн баруун болон зүүн үйлдвэрийг барьсан хөрөнгө оруулалтын зардлын тооцоолол, 2019 оноос хойш улс, нийслэлийн төсвөөс авсан татаас, татан буугдсан шийдвэр, үр дүнгийн талаарх мэдээлэл;

2025000076

7.2024 он хүртэлх агаарын бохирдлыг шийдвэрлэхтэй холбоотой улс, нийслэл, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нийт төсөв, зарцуулалтыг он тус бүрээр;

8.Цаашид агаар орчны бохирдлыг бууруулах талаар тогтвортой хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Handwritten signature of J. Baatarxuy 2025

Ц.БААТАРХҮҮ

2025000076